



**ОРХОН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Төлөвлөгөө баталсан:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../М.ОТГОНБАЯР/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

2021.12.03.....
(огноо)

ОРХОН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ЗОРИЛГО: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна. /Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны төлөвлөгөө зарлиг/							
1.1.1	Жаргалант сумыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбох	-	Онлайн сүлжээнд холбогдсон эсэх;	Орхон аймгийн Баян-Өндөр сум улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон.	Жаргалант сумыг онлайн сүлжээнд холбосон байна.	2021.01.16нд Жаргалант сумыг иргэний бүртгэлийн онлайн сүлжээнд холболоо.	100%
1.1.2	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах	-	Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан тоо;	2020 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 5 засвар үйлчилгээг хийсэн.	Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	Техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй ажиллах нөхцөлийг хангаж программын болон техникийн гэмтэл гарсан 10 тоног төхөөрөмжийг засварласан. АХБ-ны санхүүжилтээр сумын 4 бүртгэгчид иж бүрэн компьютер олголоо. 2021.10.04нд цахилгааны саатлын улмаас сүлжээний рутер шатаж УБЕГ-аас захиалан авч сүлжээний хэвийн ажиллагааг хангаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаа.	100%
1.1.3	Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний булан бий болгох	-	Цахим үйлчилгээний булангаар үйлчлүүлсэн үйлчилгээний тоо;	-	Цахим буланг үйл ажиллагаанд хэрэглэж эхэлсэн байна.	Үйлчилгээний танхимд 2021.08.12нд цахим булан бий болгож “e-Mongolia” цахим хуудаснаас 172 иргэнд шаардлагатай	100%

						лавлагаа мэдээллийг хэвлэж үйлчиллээ. /Зургийг хавсаргав/	
1.1.4	Үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим машин, төлбөрийн системээр авах нөхцөлийг бүрдүүлж, сурталчилан ажиллах	-	-Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо; -Сурталчилсан байдал;	2020 онд И-баримт апп, цахим төлбөрийн машинаар 230 иргэн үйлчилгээ авсан.	Цахим хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна.	2021.06.03нд киоск машин тавьж үйлчилгээний төлбөр хураамжийг төлүүлж байна. 4500 орчим иргэн киоскоор 3 бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ авсан байна.	100%
ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ							
Зорилт 2. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.							
2.2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	-Бүртгэлийн тоо;	Өмнөх онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 13082, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1517, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 16611 бүртгэл хийгдсэн.	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр газраас бусад үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ-13188, газар өмчлөх эзэмших эрхийн үйлчилгээ-6835 ,хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр-1702 үйлчилгээ, иргэний бүртгэлийн чиглэлээр-13673 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлсэн.	100%
2.2.2	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох	-	-Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо; -Олгосон гэрчилгээний тоо;	2020 оны жилийн эцэст гадны аймаг нийслэлийн харьяа 12 салбар төлөөлөгчийн газар бүртгэж гэрчилгээ олгосон.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бүртгэлтэй салбар төлөөлөгчийн газрыг урьд оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ.	Салбар төлөөлөгчийн газар -6 бүртгэлээ.	100%

2.2.3	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх	-	<p>-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо;</p> <p>-Эрхийн улсын түдгэлзүүлсэн бүртгэлийн тоо;</p>	<p>2020 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 10256, хууль хяналтын байгууллагад 3226 лавлагаа мэдээллийг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 127, хууль хяналтын байгууллагад 50, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 344 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа мэдээллийг хууль хяналтын байгууллагад 1416 лавлагааг албан бичгээр тус тус олгосон.</p>	<p>Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна.</p>	<p>Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд-7478, хууль хяналтын байгууллагад-2006 лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд-128, хууль хяналтын байгууллагад-92, эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад-917 лавлагаа, иргэнд-401 лавлагаа мэдээллийг тус тус олголоо.</p>	100%
2.2.4	Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй, хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах	-	<p>-Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээх;</p> <p>-Баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг хүлээн авах;</p> <p>-Байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлах;</p> <p>-Хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах;</p>	<p>2020 оны жилийн эцсийн байдлаар 24 хуулийн этгээд татан буугдсан .</p>	<p>Улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээдийг байгууллагын цахим хуудсаар нийтэд зарласан байна.</p> <p>Хуульд заасан хугацааны дараа хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах бүртгэл хөтөлсөн байна.</p>	<p>Сангийн яамнаас улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээдийн нэрс ирүүлээгүй байна.</p>	0%

2.2.5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн хариуцлагын даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	-Гэрээний хэрэгжилтийн хувь;	-	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулж, гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	УБЕГ-аас нийслэл орон нутгийн эд хөрөнгийн бүх бүртгэгчдийг 1 жилийн хугацаагаар “ХААН” даатгалд хамруулсан.	100%
-------	---	---	------------------------------	---	--	--	------

Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.

2.3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд төлөвлөгөөт 2093, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 203 хяналт шалгалт хийж, 22 дүгнэлт гаргасан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна.	2021 онд хяналт шалгалтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө батлуулж иргэний улсын бүртгэлийн чиглэлээр - 3188, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-127, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-658 бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт тавьсан. Нийт 45 зөрчил илэрснээс 28 зөрчлийг тухай бүр нь арилгуулах арга хэмжээ авсан. Бүртгэлийн зөрчилтэй холбоотой 106 өргөдөл гомдлыг хүлээн авч хяналтын байцаагчийн дүгнэлт үйлдэн зөрчлийг бүрэн арилгасан.	100%
-------	---	---	----------------------------------	---	---	--	------

2.3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчилтэй иргэдийн тоо; -Зөрчлийг арилгасан тоо;	2020 онд мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 769 иргэдийн зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т албан бичиг хүргүүлж арилгуулсан.	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн зөрчлийг 100% арилгасан байна.	Иргэний бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 228 иргэний зөрчлийг ИУБГ-т хүргүүлж арилгалаа.	100%
2.3.3	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	-	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;	2020 онд нийт 4168 бүртгэлд хяналт шалгалт хийж, 68 зөрчил илрүүлж арилгасан.	Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна.	Архивын чиглэлээр 4606 бүртгэлд хяналт тавихад баяжилтыг оруулаагүй зөрчил илэрсэн. Шинээр баригдсан орон сууцны хороолол Уурхайчин-1 хотхоны 104 айлын салгасан бүртгэлд хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах хяналтын байцаагчийн 01, 02 дугаартай албан шаардлагыг хүргүүлж зөрчлийг арилгасан.	90%
2.3.4	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо;	2020 онд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 827 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 24548000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн	Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.	Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 156 иргэн, 1 хуулийн этгээдээс 4010000 төгрөгийн торгууль оногдуулж прокурорт хугацаанд нь хянуулсан.	100%
2.3.5	Аймгийн хэмжээнд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах	-	Арилгасан зөрчлийн тоо;	-	Иргэний оршин суугаа газрын хаягийн зөрчлийг арилгасан байна.	56 иргэний хаягийн бүртгэлийн зөрчлийг бүрэн арилгууллаа.	100%

Зорилт 4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

2.4.1	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах	-	Архивын стандартын хэрэгжилтийн хувь;	2020 онд архив албан хэрэг хөтлөлтийн үзлэгээр 93 хувиар дүгнэгдсэн.	Архивын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	Гурван бүртгэлийн архивын ус чийг, дулаан хэмжилтийг тогтмол хийж архивын стандартын дагуу галын аюулаас хамгаалах хэрэгсэл, аврах схем зураглалыг байршуулж, баримтыг он дарааллын дагуу товъёог хийж хуулийн дагуу архивын нэгж үүсгэн хадгалсан. Аймгийн ОБГ-аас галын аюулгүй байдлыг хангах талаар зөвлөгөө авч ажиллаа. Улсын архивын үзлэгтэй холбогдуулан ажлын хэсэг томилж, төлөвлөгөө гарган архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллаа.	100%
2.4.2	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллого хийж, баримтыг данс бүртгэлжүүлэх	-	-Тоолсон иргэний баримтын тоо; -Тоолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо; -Тоолсон эд хөрөнгийн хувийн тоо;	2020 оны жилийн эцэст иргэн-7256, хуулийн этгээд-700, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн-16611 баяжилтын баримт архивт хадгалагдаж байна.	Хэлтсийн иргэний баримтын архивыг 100% тоолсон байна.	Иргэний бүртгэлийн-6797, Хуулийн этгээдийн -671, Эд хөрөнгийн бүртгэлийн - 15914 баяжилтыг өдөр бүр архивт хийж стандартын дагуу хадгалагдаж байна.	100%
2.4.3	Байгууллагын ББНШАЗКын үйл ажиллагаанд хяналт тавих, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах	-	-Устгасан баримт бичгийн тоо;	-	Архив бичиг хэргийн стандартыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.	Байгууллагын ББНШАЗКын хурал хийж хөтлөгдөж дууссан 10754 ш баримтыг устгалд орууллаа.	100%

ГУРАВДУГААР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

3.1.1	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, дэд төлөвлөгөө батлах	-	-Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийн хувь; -Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	-	Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна.	УБЕГ-аас Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө ирүүлсний дагуу 27 заалт бүхий дэд төлөвлөгөө гаргаж хэрэгжилт 100 хувь биелэгдлээ. Сонгуультай холбоотой ямар нэг зөрчил маргаан гараагүй болно.	100%
3.1.2	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	-Хууль тогтоомжийн дагуу мэдээ, тайланг үнэн, зөв гаргасан байх; -Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх;	Хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдийг мэдээ, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.	Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	УБЕГ болон АЗДТГ-т холбогдох мэдээ тайланг хуулийн хугацаанд бүрэн хүргэж ажиллаа.	100%

ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.

4.5.1	Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	-	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх; -Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;	2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 100 хувьтай хэрэгжсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	УБЕГ-ын даргатай байгуулах хэлтсийн даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаа.	100%
4.5.2	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2021”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	-Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд 5 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй гарсан.	Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	2021 оны хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө баталж төлөвлөгөөний дагуу 18 улсын бүртгэгч тухайн өгөгдсөн сэдвээр хэлтсийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа. ТА3-өөс зохион байгуулсан 2	100%

						удаагийн онлайн сургалтад-17 бүртгэгч хамрагдлаа. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, төрийн болон албаны нууцын тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн тухай 42 итгэмжлэгдсэн ажилтанд онлайн сургалт явуулсан. Нийт албан хаагчдад монгол хэл бичгийн хичээлийг 7 хоног бүр орж анхан шатны мэдлэг олгов. Байгууллагын харилцаа амжилтын үндэс сургалтад -25 албан хаагч хамрагдав.	
4.5.3	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан хаагчийн тоо;	-	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	УБЕГ-ын сургалтын нэгдсэн системээр зохион байгуулсан цаг үеийн сургалтуудад холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулсан.Сургалтад эд хөрөнгийн-6, хуулийн этгээдийн-1, иргэний-9 бүртгэгч тус тус 4 удаа хамрагдлаа. Удирдах ажилтнуудын сургалтад Хэлтсийн дарга, ХУБ, ЭХЭБ ийн тасгийн дарга нар хамрагдав.Сангийн яамны сургалтад ня-бо 2 удаа, УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалтанд 2 архивч, бичиг хэргийн ажилтан тус тус хамрагдлаа. Бүсийн сургалтанд бүх албан хаагчид /25/ хамрагдсан.	100%

4.5.4	Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулах богино, зорилтот, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудад албан хаагчдыг төрөл бүрийн хэлбэрээр хамруулах	Орон нутгийн төсвөөс	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо;	-	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан богино хугацааны мэргэшүүлэх сургалтад-6 бүртгэгчийг, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах тайлагнах сургалтад-4 бүртгэгч, Алсын хараа-2050 сургалтад-2, Удирдлагын арга барил сургалтанд Хэлтсийн дарга, Дэлхийн стандарт монголд "чанарын сургалт" д 4 албан хаагчийг тус тус хамруулсан.	100%
-------	--	----------------------	---	---	--	--	------

Зорилт 6. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.

4.6.1	Хэлтсийн байртай болох асуудлаар холбогдох арга хэмжээ авах	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;	-	Төлөвлөгөөт ажил хэрэгжсэн байна.	Хэлтсийн байртай болох асуудлаар, Аймгийн Засаг Дарга болон харьяалах хуулийн хэлтсийн даргад албан бичгээр, хөрөнгө оруулалт хариуцсан орлогч даргад хүсэлт саналаа хүргүүлэн ажиллаа. Мөн ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Наранцогт нарт хэлтсийн байр, архивын үйл ажиллагааг газар дээр нь үзүүлж байрны асуудал зайлшгүй хэрэгцээтэйг танилцууллаа. Аймгуудын Бүртгэлийн хэлтсийг үе шаттайгаар байртай болгож байгаа үлдсэн	50%
-------	---	---	--------------------------------	---	-----------------------------------	--	-----

						аймгуудын асуудлыг шийднэ гэдгийг ярьсан бөгөөд барилгын нийт талбайн хэмжээ, хүчин чадал зэрэг мэдээлэлийг ХЗДХЯ гаргаж хүргүүлэн өөрийн зүгээс шалтгаалах арга хэмжээ бүрэн авсан..	
4.6.2	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь; -Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байдал;	2020 онд тус хэлтэст нийт 18 өргөдөл гомдол ирснийг 100% шийдвэрлэж хариуг өгсөн. /Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна./	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд иргэдээс 16 өргөдөл гомдол ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн.	100%
4.6.3	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих	-	-Баримт бичгийн эргэлтийн тоо; -Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь;	2020 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 2261 бичиг ирсэн, үүнээс хариутай албан бичиг 1625 байсан. Хариутай албан бичгийг шийдвэрлэлтийн байдал 100 хувьтай.	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна.	Тайлант хугацаанд нийт 2565 албан бичиг ирснээс хариутай албан бичиг-1670 явуулсан албан бичиг-1560 Албан бичгийг 100 хувь шийдвэрлэж хариу хүргүүлээ.	100%
4.6.4	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; -Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;	-	Үйл ажиллагаандаа дүрэм, журмыг мөрдөж, стандартын зөрчил гараагүй байна.	Тайлант хугацаанд байгууллагын дотоод журам, стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд байнга хяналт тавьж ёс зүйн зөрчилгүй ажиллахын зэрэгцээ 7 хоног бүрийн хэлтсийн шуурхайд хэрэгжилтийг тайлагнадаг.	100%

4.6.5	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулах ажлыг зохион байгуулах	-	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан эсэх;	-	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Онош лабораторитой хамтарч 35 аас дээш насны 11 албан хаагчийг үзлэг оношлогоонд хамруулав.	100%
4.6.6	Даргын зөвлөлийн болон бүх албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтөлж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Хөтөлсөн хурлын тэмдэглэлийн тоо; -Үүрэг даалгаврын тоо; -Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь;	2020 онд 38 удаагийн даргын зөвлөлийн шуурхай хуралдаан зохион байгуулж, албажуулсан ба нэгжүүдэд 45 үүрэг даалгавар өгөгдсөний хэрэгжилт 97 хувийн биелэлттэй.	Тэмдэглэлийг тухай бүр нь албажуулан хурлаас өгөгдсөн үүрэг, даалгаврууд бүрэн хэрэгжсэн байна.	Даргын зөвлөлийн хурал 14 удаа хуралдаж цаг үеийн асуудлаар шийдвэр гаргаж үүрэг даалгавар өглөө. 7 хоног бүр хэлтсийн шуурхай хийж, /44 удаа/ АЗДТГ-аас өгсөн мэдээлэл болон УБЕГ-аас ирсэн тушаал шийдвэр, чиглэлийг танилцуулж үүрэг даалгавар өгснөөс 49 үүрэг биелэгдэж 1 үүрэг даалгавар биелэгдээгүй байна.	90%
4.6.7	Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даргын тушаал шийдвэрийг хяналтад авч бүртгэл хөтлөх	-	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой даргын тушаал, шийдвэрийн тоо, хяналтад авсан эсэх;	2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын 87 тушаал, 27 үүрэг даалгавар ирсэн.	Тушаал шийдвэрийн бүртгэлийг сар, өдрийн дарааллаар нарийн хөтөлсөн байна. Хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	УБЕГ ын даргын тушаал-42 хэлтсийн даргын-41 тушаалыг хяналтад авч бүртгэн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаа.	100%
4.6.8	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах	-	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх;	2020 онд Төрийн болон албаны нууцтай холбоотой хариутай 11 албан бичиг ирсэн. хариуг явуулсан.	Хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Төрийн болон албаны нууцтай холбоотой 35 албан бичиг ирж хуулийн дагуу хариуг холбогдох газарт нь хүргүүллээ. Бүртгэгч нарын компьютерт үзлэг шалгалт хийлээ. Шинээр томилогдсон иргэний улсын бүртгэгчид нууцын тухай хууль журмыг танилцуулж нууцын баталгаа гаргуулан авлаа.Орхон аймаг дахь Тагнуулын газраас нууцын	100%

						бичиг баримтанд шалгалт хийж зөвлөгөө зөвлөмж өглөө.	
4.6.9	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;	-	Сар бүр мэдээлэл байршуулсан байна.	Байгууллагын https://orkhon.burtgel.gov.mn/ вебсайт Дээр 149-н мэдээ мэдээлэл тавигджээ. Вебсайт дээр нийтэлсэн мэдээллүүдэд хандсан хүн 6324 байна.	100%
4.6.10	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	-Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл; -Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст хүргүүлсэн байдал;	2020 онд эд хөрөнгийн маргаантай 5 шүүх хуралд оролцсон.	Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, байгууллагын эрх ашгийг бүрэн хамгаалсан байна.	Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн маргаанд Улсын ахлах бүртгэгч, эд хөрөнгийн ахлах бүртгэгч нар тус тус 3 хуралд төлөөлөн оролцож хэрэг маргааны судалгааг холбогдох газарт цаг хугацаанд нь хүргүүллээ.	100%

4.6.11	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох	-	-Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулсан тоо; -Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо;	2020 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг цахим болон фэйсбүүк хуудсанд 1756 удаа байршуулсан. Орон нутгийн телевиз, сонинд 8 удаа мэдээлэл хийсэн.	Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн чанартай хийж хэрэгжүүлж буй ажлын талаар иргэд, олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна.	2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 02-ний хооронд нийт 142 мэдээ мэдээллийг бэлтгэн иргэдэд түгээсэн байна. Хэлтсийн фэйсбүүк хуудас нь 3002 like-тай, 3500-н дагагчтай. Фэйсбүүк хуудсан дээр нийтлэгдсэн мэдээ мэдээлэл дунджаар 1000-1500-н хүнд тогтмол хүрдэг. Орон нутгийн хоёр ТВ ээр бүртгэлийн хууль журмын талаар иргэдэд сурталчилсан. Засаг Даргын дэргэдэх хэвлэлийн ажилтанд 7 хоног бүр мэдээлэл өгч ажилласан.	100%
4.6.12	Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах	-	“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо;	2020 онд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2 удаа зохион байгуулсан.	Нээлттэй хаалганы өдөрлөгийг 5-с доошгүй удаа зохион байгуулсан байна.	Цар тахлын улмаас хэрэгжих боломжгүй байна.	0%
4.6.13	Иргэдийн санал хүсэлтийг сонсох 70358989 утасны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	-	-Утсаар лавлагаа мэдээлэл авсан тоо;	Хэлтсийн лавлах 70358989 утсанд 86 иргэн утсаар холбогдож асуудлаа, тухай бүр шийдвэрлэсэн.	Улсын бүртгэлийн чиглэлээр иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэсэн байна.	Иргэний санал хүсэлтийг сонсох 70358989 утсаар 877 иргэний хүсэлтийг авч зөвлөгөө мэдээллийг шуурхай хүргэлээ.	100%
Зорилт 7. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана.							
4.7.1	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах	-	Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх;	2020 онд орон нутгийн санхүүжилтээр 42734330 төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдүүлсэн.	Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна.	Аймгийн ЗДТГ тай хамтран ажиллах ажлын хүрээнд хэлтсийн байрны сарын түрээсийг-400000 төгрөгөөр багасгаж тайлант хугацаанд 4800000 төгрөгийг хэмнэлээ. Мөн 4 гэрээт ажилтны цалин хөлс болох	100%

						25200000 төгрөгийн асуудлыг бүрэн шийдвэрлүүлсэн. Мөн 2022 оны аймгийн төсөв батлуулахад гэрээтүүдийн цалинг нэмэгдүүлэхээр батлуулав./4 гэрээт/	
Зорилт 8. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.							
4.8.1	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах	Батлагдсан төсөв	-Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх; -Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх;	2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч зөрчлийг 33,3 хувиар бууруулсан. 2020 онд 499,6 сая төгрөгийн урсгал төсвөөс 495,4 сая төгрөгийг зарцуулсан.	Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна.	2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч, зөрчлийг 50 хувиар бууруулсан. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 423,7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас-399,9 төгрөгийг зарцуулсан байна. Тайлант хугацаанд цалин хөлсний-9,2 сая ашиглалтын зардлын-2385,1 сая бичиг хэргийн зардлын 0,4 сая төгрөгийн өр үүсээд УБЕГ т хандан шийдвэрлүүлсэн .	100%

4.8.2	Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах	-	<p>-Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх;</p> <p>-Үнэт цаас, маягт болон бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх;</p> <p>-Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх;</p>	2020 онд УБЕГ аас 12,8 сая төгрөгийн тусгай зориулалтын бараа материал, 1,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан. Бараа материалын тасалдал, өр авлага үүсгэлгүй ажилласан.	Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна.	2021 онд УБЕГ-с 54,9 сая төгрөгийн тусгай зориулалтын бараа материал, бусад байгууллагаас 5,8 сая төгрөгийн бараа материал тус тус шилжүүлэн болон худалдан авсан бөгөөд бараа материалын тасалдал үүсээгүй болно. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2021.12 дугаар сарын 13-15 ны өдрүүдэд явуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2020 оны өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт болон холбогдох баримтыг ТӨБЗГ т хугацаанд нь хүргүүлэн “92А буюу хангалттай” үнэлгээ авлаа.	100%
4.8.3	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах	-	<p>-Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо;</p> <p>-Хугацаандаа байршуулсан эсэх;</p>	2020 оны 12 сарын 25-ны байдлаар шилэн дансны цахим сайтад 133 төрлийн мэдээлэл оруулахаас 133 мэдээллийг хугацаа хоцролгүй, үнэн зөв байршуулсан.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	2021 оны эхний 11 сарын байдлаар шилэн дансны цахим сайтад 136 төрлийн мэдээлэл оруулахаас 136 мэдээллийг хугацаа хоцроолгүй үнэн зөв байршуулсан. Мөн түүнчлэн байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд сар бүр тогтмол мэдээлэл байршуулсан байна.	100%

4.8.4	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, тогтмолжуулах	-	<p>-Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах;</p> <p>-Хүчингүй болсон үнэт цаас, тамга тэмдгийг журмын дагуу устгах;</p> <p>-Төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогод бэлтгэх;</p> <p>- Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх;</p> <p>-Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сантай болох;</p> <p>-Хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмжийн ашиглалт үзүүлэлтийн судалгаа гаргах;</p> <p>-Тайланг 2 удаа хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах;</p>	Байгууллагын эд хөрөнгийн тооллого, хүчингүй болгосон үнэт цаасны зарцуулалт, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах зэргээр 2 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.	Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна.	Тайлант хугацаанд “Өмч хамгаалах зөвлөл” нь байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй бүтцийн өөрчлөлт, хууль журмын өөрчлөлтөөс болон цаашид ашиглах боломжгүй болсон 8,3 сая төгрөгийн үнэ бүхий тусгай зориулалтын болон бусад хангамжийн бараа материалыг актлах, 2020 онд бүртгэгчийн болон техникийн алдаанаас хүчингүй болсон 13 нэр төрлийн 846 ширхэг үнэт цаасыг устгах ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа. Иргэний бүртгэлийн онлайн сүлжээ нэвтэрч программ шинэчлэгдсэнтэй холбоотой цаашид ашиглагдахгүй болсон 29,1 сая төгрөгийн өртөг бүхий 4 нэр төрлийн 27 ш үндсэн хөрөнгийг актлуулахаар техникийн дүгнэлтийн хамт хүргүүлээ.	100%
-------	---	---	--	--	---	---	------

ТАВДУГААР ЗОРИЛГО: МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 9. “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
5.9.1	Монгол бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэхээр бие даан суралцах, сургалтад хамрагдах	Монгол бичгийн чадвартай болох	Монгол бичгийг бие даан судлах болон онлайн сургалтад хамрагдах	Монгол бичгийн хичээл хэлтсийн хамт олондоо заалгаж анхан шатны мэдлэгтэй болсон. /монгол бичиг үзсэн бүртгэгч хичээл зааж байна/	100%

5.9.2	УБЕГ-аас болон аймаг орон нутгаас зохион байгуулсан онлайн болон танхимын сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлэх	Хууль тогтоомжийн мэдлэг дээшилсэн байх	Улсын бүртгэлийн багц хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, Төрийн болон албаны нууцын тухай хуулийг судалж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Алсын хараа 2050” 40 цагийн хичээл, ”Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх 16 цагийн хичээлд тус тус хамрагдаж үнэмлэх авлаа. Мөн УБЕГ-аас зохион байгуулсан удирдах ажилтны сургалт, үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ цахим сургалт, хэлтсийн дарга нарын 2 удаагийн цахим сургалт, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, төрийн болон албаны нууцын тухай хуулиар онлайн сургалтуудад, нийгмийн даатгалын багц хуулийн сургалт, кибер орон зай дахь аюулгүй байдал сургалтуудад, АЗДТГ аас зохион байгуулсан “Удирдлагын арга барил” сургалт, Чанар стандартын сургалтуудад тухай бүр нь хамрагдлаа.	100%
-------	--	---	--	--	------

Төлөвлөгөөг хянасан: **Төсвийн Ерөнхийлөн захирагч**
 /...../
 (албан тушаал) (гарын үсэг) (огноо)
 Тэмдэг

Төлөвлөгөө тайлагнасан: **Төсвийн Шууд захирагч**
 /...../
 (албан тушаал) (гарын үсэг) (огноо)

